



## ГАДААД ХЭЛНИЙ СУРГУУЛИЙН ДОКТОР ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

Хурлын зорилго: Хэл шинжлэл, гадаад хэл заах арга зүй, орчуулгын онол арга зүй, нэр томьёо судлалын чиглэлээр судалгаа хийдэг судлаач, багш, эрдэмтдийн хамтын ажиллагааг дэмжих, харилцан туршлага судлах, салбар тус бүрийн судалгааны ажлын явц, цаашдын чиг хандлагыг таниулахад уг хурлын зорилго оршино.

Хурлын сэдэв:

- ✧ Технологи ба хэлний боловсрол
- ✧ Зэрэгцүүлсэн хэл шинжлэл
- ✧ Орчуулгын онол, арга зүйн асуудлууд
- ✧ Гадаад хэл заах арга зүй
- ✧ Нэр томьёо судлал
- ✧ Боловсрол судлал

Хугацаа:

Илтгэлийг 2024 оны 03 дүгээр сарын 29-ний өдөр хүртэл [cheeme99@must.edu.mn](mailto:cheeme99@must.edu.mn) хаягаар хүлээн авна. Эрдэм шинжилгээний хурал 2024 оны 04 сарын 02-ны өдөр 10:00~14:00 цагт Т байрны 207 тоотод болно.

Илтгэлд тавигдах шаардлага:

1. Судалгааны ажлын зорилго, зорилт тодорхой байх
2. Шинжлэх ухаан инновацын шинэлэг тал, үр дүнг тодорхой тусгасан байх
3. Судалгааны ажлын арга аргачлал тодорхой байх
4. Судлаачын бүтээлээс магистрант 6-аас доошгүй, докторант 12-оос доошгүй эшлэл авсан байх
5. Эрдэм шинжилгээний давхцалыг шалгуулсан байх
6. Илтгэх ур чадвар эзэмшсэн байх
7. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлд хэвлүүлэх ЭШӨ-ийн шинэчилсэн загварын дагуу бичигдсэн байна.

Дүгнэх журам:

Комиссын бүрэлдэхүүн илтгэлийн шинжлэх ухааны үндэслэл, шинэлэг санаа дэвшүүлсэн байдал, асуудал дэвшүүлж тодорхой үр дүнд хүрсэн байдал, нийгэм болон мэргэжлийн хүрэн дэх ач холбогдол, судалгааны арга аргачлал зэрэг үзүүлэлтээр дүгнэж шалгарсан 3 судлаачийг ШУТИС-ийн магистр, доктор оюутны “ЭРДМИЙН ЧУУЛГАН 2024” ЭШХ-д оролцуулахад тодорхойлно